

МОНГОЛ УЛС БА ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

*А.Буянтөгс**

1990 онд улс төр, эдийн засгийн өөрчлөлт эхлүүлснээс хойш Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалт /ГХО/-ыг дэмжихэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж эхэлсэн. “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай” хуулийг УИХ-аар хэлэлцэн 1991 онд анх баталж, 1993, 1998 болон 2002 онуудад тодорхой нэмэлт өөрчлөлтүүд оруулсан бөгөөд эдгээр нь хөрөнгө оруулалтын илүү тааламжтай орчинг бий болгоход чиглэгдсээр ирлээ.

ГХО нь Монгол Улсын Үндсэн хууль, ГХО-ын тухай хууль, бусад хууль, тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан байдаг.

Монгол Улсын Засгийн газар нь “Давхар татвараас чөлөөлөх тухай” хэлэлцээрт 31 улстай, “Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах хоёр талт хэлэлцээр”-т 37 улстай тус тус гарын үсэг зурсан ба “Хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай” 1965 оны Вашингтоны конвенцид 1996 онд, “Хөрөнгө оруулалтын даатгалын олон талт агентлаг байгуулах тухай” 1985 оны Сөүлийн конвенцид 1999 онд тус тус нэгдэн орсон билээ.

Түүнчлэн Монгол Улс нь Дэлхийн банкны хөрөнгө оруулалтын олон талт даатгалын агентлагийн /MIGA/ гишүүн бөгөөд хөрөнгө оруулагчид MIGA-гийн эрсдлийн даатгалд хамрагдах эрхтэй юм.

Монгол Улсын Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулагчдад дараах төрлийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлдэг байна. Үүнд:

1. Дулааны цахилгаан станц, цахилгаан, дулаан дамжуулах шугам, сүлжээ, авто зам, төмөр зам, агаарын тээврийн болон инженерийн барилга байгууламж, харилцаа холбооны үндсэн сүлжээний салбарт татварыг 10 жилийн хугацаагаар чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

2. Нефть, хатуу түлш олборлох, боловсруулах, металлург, хими, төмөрлөг, машины үйлдвэрлэл, электроникийн салбарт татварыг 5 жилийн хугацаагаар чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

3. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортолж байвал тухайн аж

*А.Буянтөгс - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

ахуйн нэгжийг орлогын албан татвараас 3 жилийн хугацаагаар чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

Засгийн газраас 2001 онд хөрөнгө оруулах ач холбогдол бүхий тэргүүлэх салбарын жагсаалтыг баталсан юм. Тухайлбал, үр тариа, эрчимжсэн мал аж ахуй, нүүрс, газрын тос, ашигт малтмал олборлолт, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэл, үслэг эдлэл, арьс шир боловсруулалт, мод модон эдлэл, төмөрлөг, химийн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эдийн боловсруулалт, дэд бүтцийн зарим салбар, аялал жуулчлал зэрэгт хамаарагдах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд гадаадаас орж ирж буй технологийн зориулалттай тоног төхөөрөмж нь НӨТ, гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд орсон өөрчлөлтөөр алтны экспортын 10 хувийн татварыг хүчингүй болгосон нь алт олборлодог компаниудаас тус салбарт хөрөнгө оруулалт хийх итгэл, найдварыг төрүүлсэн юм.

Гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд нь хууль эрх зүйн баталгаа, хамгаалалттай байдаг бөгөөд тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглох; гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад Монголын хөрөнгө оруулагчдад олгогдоос дутуугүй тааламжтай нөхцөл олгох гэх зэрэг урамшуулал үзүүлдэг.

Мөн гадаадын хөрөнгө оруулагчид нь дараах эрх эдэлдэг. Үүнд:

- 2 сая ам.доллараас дээш хэмжээний хөрөнгө оруулалт оруулсан гадаадын хөрөнгө оруулагч нь Монгол Улсын Засгийн газартай Тогтвортой байдлын гэрээ байгуулах,

- Монгол Улсад аж ахуйн нэгж бүртгүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх эрхтэй,

- Мөн гадаадын хуулийн этгээдийн салбар байгуулж болно.

Одоо дэлхийд хөрөнгө оруулалтаар тэргүүлэгч АНУ, Европын холбоо, Япон гэсэн хөгжлөөрөө дээд шатанд гарсан гурвалжин бий болжээ.

Зөвхөн тааламжтай нөхцөл бүрдүүлээд ГШХО ихээр орж ирэхэд найдах нь хангалтгүй юм. Дэлхий нийтийн хандлагаас харахад үр ашигтай, тогтвортой хөгжиж буй зах зээл рүү ГШХО ихээр орж ирж байна. 60-70-аад онд аж үйлдвэр хөгжингүй орнуудаас ГШХО хөгжиж буй орнууд руу орж байсан бол 80-90-ээд онд аж үйлдвэр хөгжингүй

орнууд харилцан хөрөнгө ихээр оруулж байна. Үндсэн капиталын урсгалууд хүн амын дундаж орлого их, дотоод зах зээлийн багтаамж ихтэй хөгжингүй орнуудын хооронд явагдаж байна. Дэлхийд эхний 10 хөрөнгө оруулалт импортлогч орнуудын тоонд АНУ, Их Британи, Хятад, Голланд, Бразил, Франц, Бельги, Герман, Швед, Канад, экспортлогч орнуудад АНУ, Их Британи, Герман, Франц, Голланд, Канад, Япон орж байна. Иймээс макро эдийн засгийн тогтвортой бодлогын ач холбогдол маш өндөр юм. Европын холбоонд хамгийн том хөрөнгө оруулагч нь АНУ юм. 1950 оны байдлаар АНУ-аас гадаад орнуудад оруулсан хөрөнгийн 15 хувь нь Европын холбоонд оногдож байсан бол 1998 онд 50 хувь оногдох болсон байна. Сүүлийн 30 жилд ГШХО ихээр хүлээн авагч үндсэн 10 орон Аргентин, Бразил, Мексик, Саудын Араб, Хятад, Индонез, Малайз, Сингапур, Тайланд, Сянган байжээ. Гол хүчин зүйлүүд нь эдгээр орнуудын дотоод зах зээлийн багтаамж их байсанд байжээ. Азийн санхүүгийн хямрал нь хөрөнгийн нөөцийн хязгаарлагдмал байдлыг харуулж энэ бүс нутгуудад цаашид ГШХО-ыг ихээр оруулах шаардлагатайг харуулсан байна. Хэдийгээр ГШХО нь хөгжингүй болон хөгжиж буй орнуудын эдийн засагт сайн нөлөө үзүүлж буй боловч эдийн засгийн өрсөлдөөн, үндэсний аюулгүй байдлын бодлогын үүднээс улс орнууд зарим стратегийн салбарт ГШХО-ыг хязгаарлах бодлого явуулдаг байна. Тухайлбал, Франц, Япон, Их Британи, АНУ зэрэг орнууд харилцан аэронавтик, автомашин, электроник, банк, даатгал, агаарын тээвэр зэрэг салбарт ГШХО-ыг хязгаарлах бодлого явуулж байна.

Хятад, Энэтхэг өөрсдийн өрсөлдөх чадвартай болсон хүнс, өргөн хэрэглээний барааны салбарт ГШХО-ыг хязгаарлах эдийн засгийн бодлого явуулж байна. Энэтхэгийн Аж үйлдвэрийн холбооны ерөнхийлөгч асан Энэтхэгт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын үндэстэн дамнасан корпорацуудын үйл ажиллагааны зарим сөрөг байдлыг дараах байдлаар тодорхойлжээ.

- тэд үйлдвэрлэлээс илүү худалдааг эрхэмлэж байна,
- ихэнхдээ урт хугацааны төслөөс илүү богино хугацааны төсөлд анхаарлаа төвлөрүүлж байна,
- хуучин технологи оруулж байна, тэдний хөрөнгө оруулалт хуучин /second-hand/ тоног төхөөрөмжөөр хязгаарлагдаж байна.
- тэд 50:50 хувийн хувьцаатай орж ирээд хурдан хугацаанд хяналтын хувьцааг эзэмшихийг оролддог /Энэтхэгт олон жилийн турш

50:50 харьцаатай хамтарсан аж ахуйн нэгжийн төслүүд, 100 хувийн хөрөнгө оруулалттайг бодвол маш түргэн шийдэгдэж иржээ./

- нутгийн түншүүдтэй хамтарсан аж ахуйн нэгжтэй мөртлөө бусад салбарт 100 хувийн оролцоотой салбар байгуулдаг,

- Энэтхэгийн мэргэжилтнүүд байсаар байтал гадаадаас удирдах албан тушаалын хүмүүсийг ажиллуулдаг,

- зарим салбарыг гадаадаас нүүлгэн авчирахдаа экологид сөрөг нөлөөтэй бохирдуулдаг тоног төхөөрөмж авч ирдэг,

- санхүүгийн байдлаа ашиглаж өөрсөдлөө тааламжтай нөхцөл байдал олж авахын тулд нутгийн улс төрчид, орон нутгийн удирдлагуудад нөлөөлөхийг оролддог гэжээ.

Иймэрхүү байдлаас зайлсхийхийн тулд манай бодлого боловсруулагчид хөрөнгө оруулагчдыг анхааралтай судалж, тогтвортой байдлын гэрээ хийхдээ ч анхаарах нь зүйтэй юм.

Улс орнуудын ГШХО-ыг урамшуулах шалтгаан нь харилцан адилгүй байдаг байна. Тухайлбал:

- Ажилгүйдлийг багасгах нийгмийн тогтвортой байдал /Франц, Их Британи/

- Аж үйлдвэрийн бүтцийн өөрчлөлт, байгалийн баялгийг эзэмших /Бразил, Чили, Венесуэл/

- Экспортыг хөгжүүлэх, мэргэжлийн туршлага олж авах /Хятад/

- Хөдөө аж ахуй, олборлох салбарыг хөгжүүлэх /Аргентин, Австрали/

- ОУВС зэрэг олон улсын донор байгууллагын шахалт /Энэтхэг улс улс төр, соёл, түүхэн нөхцөл байдлын шалтгаанаар 1991 он хүртэл олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтаас тасархайдуу байж байгаад валютийн нөөцийн хямралаас болж ОУВС-ийн шахалтаар эдийн засагтаа зохицуулалт хийж нээлттэй бодлого явуулах болсон байна./

- Капиталыг түргэн татаж оруулах хэрэгцээ /Мексик, Тайланд, Индонези/¹ гэх мэт.

Монгол Улсын өнөөгийн эдийн засгийн байдал нь гадаад өр зээлийг хязгаарлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого барих шаардлагатайг харуулж байна. Монгол Улсад ГШХО-ыг татахад нөлөөлөх байдал, давуу тал нь:

- Улс төрийн тогтвортой байдал

- Нээлттэй эдийн засаг

- Хөрш орнуудад зах зээлд нэвтрэх боломж

- Ашигт малтмалын баялаг нөөц

- Харьцангуй залуу, боловсролтой хүн ам
- Өргөн уудам нутаг дэвсгэр
- Цэвэр онгон байгаль
- Хөрөнгө оруулалтыг дэмжих засгийн газрын бодлого
- Тогтвортой байдлын баталгаа
- Хууль эрх зүйн боломжтой орчин
- Олон улсын эдийн засаг худалдаа, банк хөрөнгө оруулалтын байгууллагууд дахь гишүүнчлэл
- Хувьчлалын бодлого

Сул тал:

- Хүнд суртал, шат дамжлага, ажил хэрэгч байдлын дутагдал
- Авилгал, хээл хахууль
- Тогтворжоогүй эдийн засаг
- Цөөн хүн ам
- Байгаль цаг уурын таатай бус нөхцөл
- Хөрөнгийн хуримтлал бага, санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал
- Гааль, татварын шийдвэрлэгдээгүй асуудлууд
- Дэд бүтцийн сул хөгжил
- Далайн гарцаас алслагдсан байдал
- Технологийн хоцрогдол
- Зах зээлийн бага багтаамж
- Банкны өндөр хүү, банкны секторын сул хөгжил
- Шүүхийн боловсронгуй бус систем, хуулийн цоорхой, хуулийн сул хэрэгжилт
- Газар хувьчлалын асуудал
- Фермерийн аж ахуйн сул хөгжил
- Мэдээлэл, сурталчилгаа сул
- Түүхий эдэд суурилсан экспортоос шалтгаалсан дэлхийн зах зээлийн үнийн хамаарал их
- Үр ашиг багатай дотоод хөрөнгө оруулалт гэх мэт.

2003 оны эцсийн байдлаар Монгол Улсад 1990 оноос хойш дэлхийн 73 орны 3083 гадаадын хөрөнгө оруулалттай компани /газрын тосны салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтыг оролцуулан/ нийт 1 тэрбум гаруй ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийгээд байна. Үүнээс: БНХАУ /333 сая ам.дол/, Канад улс /132 сая ам.дол/, БНСУ /81 сая ам.дол/, Япон /60 сая ам.дол/, АНУ /36сая ам.дол/, ОХУ

/33 сая ам.дол/ зэрэг улсууд оруулсан хөрөнгө болон компанийнхаа тоогоор тэргүүлэх хөрөнгө оруулагчид болж байна.²

Олон улсын үндэстэн дамнасан корпорациуд болох Камекогоулд, Катерпиллар, Самсунг, Сумитомо, Кока-Кола, Иточу, Комацу, Хьюндай, Проктер & Гэмбл, Форд, Мерседес Бенц зэрэг корпорациуд нь Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байна.

Цаашид гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлого боловсруулахдаа дэлхийд тэргүүлэгч ҮДК-уудтай орнуудтай түншлэх бодлогоо илүүтэй хөгжүүлэхээр бодож чиглүүлэх нь зүйтэй юм. Мөн уламжлалт хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн бүх талын түншлэлээ хөгжүүлж, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, гааль татварын бодлогоо уялдуулан зохицуулах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх бодлого, бааз суурийг чанарын шинэ түвшинд гаргах, тэргүүлэх чиглэлүүдийг тогтоох, ГШХО-ыг татах стратеги төлөвлөгөө боловсруулах нь чухал ач холбогдолтой болж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Пауль Фишер. ПИИ для России: Стратегия возрождения промышленности.
Москва, “Финансы и статистика” 1999г, стр16.
2. ГХОГХА-ийн тоо баримт
3. Монголын эдийн засаг: Өчигдөр, өнөөдөр, маргааш.
Улаанбаатар, 2002
4. ПИИ в России: плюсы и минусы, МЭ и МО, 2003 №9